Одоогоор түрээслэх боломжтой санал гараагүй л байна., Цэвэр бохирын шугам татаж оо-той болгож өгвөл зоогийн газар ажиллуулъя гэсэн нэг хүн бий. Таван жилээр гэрээ хийе гэсэн одоогоор чимээгүй болчихоод л байна.

Асуулт: Г.Эрдэнэбаатар

Яагаад алдагдалтай ажиллад байна вэ?

Хариулт: Н.Цоож

Өөрийн хөрөнгийн хүрэлцээгүйгээс банкнаас зээл авч үйл ажиллагаа явуулж байна. 3500 м2-ын агуулахыг хотын захад гээд хүмүүс түрээслэхгүй, хүн очихгүй болохоор ашиглаж чаддаггүй. Дээр нь засвар хийх хөрөнгөгүйгээс өдөр ирэх тусам чанар, өнгө үзэмж нь муудаж байна. Аймгийн ИТХ 3500 м2 агуулахыг "А" зэрэглэлийн бүс гэж тогтоогоод газрын төлбөр өндөр тогтоосон. ҮХХөрөнгийн татвар төлдөг, манаач сахиул ажиллуулж шимтгэл төлнө гээд зайлшгүй зардлууд гарч байна. УБ хотын зах, худалдааны төвүүд НӨАТ-ын баримт өгдөггүйгээс НӨАТ-ын төлбөр бидэн дээр буудаг. Хасуулж тооцуулах юм бага. Архины зөвшөөрөлтэй гээд янз бүрийн дарамт нэмэгдэл зардал их байдгаас алдагдалд орж байна. Худалдагч хийх хүн олдохгүй, сул зогсолтын мөнгө өгч торгоож байна. Худалдаа хийхээс татгалзахаас өөр аргагүй болоод байх шиг байна.

Асуулт: Ц.Энхтуяа

Ашигтай ажиллаж ногдол ашиг хуваарилах ямар боломж байна вэ?

Хариулт: Н.Цоож

Хүнсний дэлгүүрээ 1-р давхарт оруулж үзвэл борлуулалт нэмэгдэх болов уу гэж үзээд 1-р давхартаа засвар хийж хойд талаасаа шууд ордог болгох санаатай байгаа. Дан сантехникийн материал худалддаг тасагтай болвол ямар бол гэж бодож байна. Та нар энэ талаар саналаа хэлнэ биз.

Асуулт: Б.Ганбаяр

Жуулчны баазынхаа хүчин чадлыг нэмэгдүүлбэл орлого нэмэгдэнэ биз дээ

Хариулт: Н.Цоож

Хөрөнгөний боломж гарвал 4 хүний модон шовгор зургаагаас доошгүйг баривал монголчуудыг хүлээн авах, сэрүүний үе, салхи шороотой хаварт эрт нээгдэх боломж нэмэгдэж орлого өснө.

Асуулт: П.Аюусэд

ТУЗ-ийн гишүүд аль хир идэвхтэй ажиллаж байна? 3500 м2-ын агуулахыг авах хүн олдохгүй байна уу?

Хариулт: Н.Буянхүү